

ХӨДӨЛМӨРИЙН БОДЛОГЫН ГАЗРЫН НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ХЭЛТСИЙН АХМАД НАСТАН,
ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ ОЮУНБАТЫН ЦЭРЭНЛХАМЫН
2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)			
1	2	3	4	5	6	7		
Зорилт 1. “Ахмад настны хөнгөлөлт, тусlamжийн бодлогын хэрэгжилтийг хангах” зорилтын хүрээнд								
1.	Арга хэмжээ 1.1. “Ахмад настанд цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам-ын хэрэгжилтийг хангах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	20%	Монгол Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан. Уг хуулийн 4.1.8-д Ахмад настны цогц тусlamж, үйлчилгээг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтан ахмад настны бие бялдар, танин мэдэхүй, сэтгэлзүй, үйл ажиллагааны чадвар, нийгмийн тулгамдсан асуудлыг тодорхойлж, хэрэгцээ болон эрсдэлийн зэргийг үнэлж, үнэлгээнд сууринлан ахмад настны хам шинж, асран хамгаалал, нийгмийн халамжийн тусlamж, үйлчилгээний тулгамдсан асуудлыг эрэмбэлэн хэрэгцээг тогтоож, төлөвлөгөөний дагуу цогц үйлчилгээ үзүүлж, эргэн хянах үйл ажиллагаа гэж тодорхойлсон. Энэ үйлчилгээ нь Ахмад настны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар шинээр томьёолон оруулж ирсэн, шинэ үйлчилгээ бөгөөд Монгол Улсад ахмад	2025.03.01 - 2025.06.30	95%	

					<p>настны цогц тусlamж үйлчилгээний шинэлэг тогтолцоог бий болгох зорилготой.</p> <p>Ахмад настны тухай хуулийн 7.3.1-д Ахмад настанд цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журмыг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран баталж, хэрэгжүүлэхээр заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын “Журам батлах тухай” 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн A/28, A/37 дугаар хамтарсан тушаалаар “Ахмад настанд цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”-ыг баталсан.</p> <p>Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд Ахмад настны тухай хуульд заасан үйлчилгээг хэрэгжүүлэхэд салбар дундын үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх, зөвлөмж чиглэл өгөх үүрэг бүхий Мэргэжлийн хамтарсан багийн хурлыг 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр зохион байгууллаа. Уг хуралд мэргэжлийн хамтарсан багийн гишүүд болон орон тооны бус ажлын хэсгийн гишүүд оролцож Монгол Улсад ахмад настны цогц тусlamж үйлчилгээний шинэлэг тогтолцоо бий болгоход мэргэжлийн хамтарсан багийн хийх үйл ажиллагааны төлөвлөгөө, ахмад настанд цогц тусlamж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр болон орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг байгуулахад дэмжлэг үзүүлж ажиллах талаар хэлэлцэн шийдвэрлэсэн. Хурлаас гарсан шийдвэрийн дагуу</p>	
--	--	--	--	--	---	--

					Mэргэжлийн хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран батлуулж, Аймаг, Нийслэл, дүүргийн Засаг дарга наарт Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг байгуулж, ахмад настанд үзүүлэх үйлчилгээ, урт хугацааны тусlamж, үйлчилгээ, идэвхтэй насжилтын төвүүдийг орон нутагт хөгжүүлэх, хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, чиглэл хүргүүлэх албан бичгийн төслийг хамтран боловсруулж ажилалаа. Мөн Мэргэжлийн хамтарсан багийн шийдвэрийг хэрэгжүүлэх, өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах үүрэг бүхий орон тооны бус ажлын хэсгийн хуралд 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр оролцож, мэргэжлийн хамтарсан багийг хуралдуулах бэлтгэл ажлыг хангаж ажилалаа. Энэ хүрээнд мэргэжлийн хамтарсан багийн гишүүдийг холбогдох мэдээллээр хангаж бүрэн оролцуулах, хурлын хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах, хурлаар танилцуулах мэдээллийг нэгтгэх зэрэг зохион байгуулалтын ажилд хамтран оролцлоо.		
2.	Арга хэмжээ 1.2. Ахмад настанд цогц тусlamж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ЭМЯ, ГҮТ-тэй хамтран боловсруулах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Монгол Улсад ахмад настын цогц тусlamж үйлчилгээний шинэлэг тогтолцоог бий болж байгаатай холбогдуулан Ахмад настын тухай хуульд заасан ахмад настын цогц үнэлгээ хийж, цогц тусlamж үйлчилгээ үзүүлэх эмч эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор “Ахмад настанд цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”-ыг батлан хэрэгжүүлж байна.	2025.03.01 - 2025.06.30	90%

					Энэхүү журмаар Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд удирдлага, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий мэргэжлийн хамтарсан баг, үйлчилгээг үзүүлэхэд оролцогч талуудын үүрэг оролцоо, орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийн чиг үүрэг, хэрэгжүүлэх үйл ажиллагааг нарийвчлан тусгаж зохицуулсан. Уг журмын 2.6.9-д Мэргэжлийн хамтарсан баг нь үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг сургах төлөвлөгөө гарган сургалтыг зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх гэж заасны дагуу Ахмад настанд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төслийг Эрүүл мэндийн яам болон Геронтологийн үндэсний төвөөс орон тооны бус ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байгаа албан хаагчидтай хамtran боловсруулж, Мэргэжлийн хамтарсан багийн 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр хурлаар хэлэлцүүлсэн. Хурлаас Ахмад настанд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах төсвийн зардлын эх үүсвэр тодорхой биш бөгөөд төсвийн зардал их гарахаар төлөвлөгдсөн гэж дүгнэн сургалтын төсвийг дахин сайжруулж төлөвлөхөөр шийдвэрлэсний дагуу сургалт зохион байгуулах зардлын тооцоог боломжит хувилбараар багасгаж, дахин сайжруулан ажиллаж байна.	
					Монгол Улсад ахмад настны цогц тусламж үйлчилгээний шинэлэг тогтолцоог бүрдүүлж, шинэ үйлчилгээг нэвтрүүлж байгаатай холбогдуулан үйлчилгээ үзүүлэх иргэн, аж	2025.03.01 - 2025.06.30

3.	Арга хэмжээ 1.3. Ахмад настанд цогц тусламж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	20%	<p>ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна. Иймд Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан албажуулж, сургалтуудыг бүсчлэн үе шаттай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. “Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”-д Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг аймаг, дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулж, нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга удирдана гэж заасны дагуу Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаас аймаг, дүүргийн Засаг дарга нарт орон нутагтаа мэргэжлийн хамтарсан баг байгуулж ажиллах талаар чиглэл зөвлөмж хүргүүлэх, мэргэжлийн хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөг албан бичигтэй хамтагтан хүргүүлэхээр боловсруулан ажиллаж байна. Мөн Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлсэн төслийн хүрээнд зохион бүтээгдсэн кейс менежментийн аппли케йшныг хүлээн авах асуудлыг судлан шийдвэрлэх, ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх үнэлгээ хийхэд туршилтын журмаар ашиглаж эхлэх зэрэг ажлуудыг 2025 онд багтаан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Тус аппликеийшныг ашигласнаар ахмад настны тулгамдсан асуудлыг тодорхойлж, хэрэгцээ болон эрдээлийн зэргийг үнэлэх ажилтныг тусгайлан мэргэшүүлж, чадавхжуулах шаардлагагүй</p> <p style="text-align: right;">70%</p>

				болов бөгөөд үнэлгээ хийх цаг хугацааг хэмнэж, ахмад настанд цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэх ажилтнуудад ажлын ачаалал бага үүсгэх давуу талтай.	
--	--	--	--	--	--

**Зорилт 2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусlamжийн бодлогын хэрэгжилтийг хангах”
зорилтын хурээнд**

1.	Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 хамтарсан тушаалыг шинэчлэн боловсруулах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.11-д ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг тодорхойлох шалгуур үзүүлэлт, өвчин, гэмтлийн жагсаалтыг эрүүл мэндийн болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална гэж заасны дагуу Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 хамтарсан тушаалаар Жагсаалт, шалгуур үзүүлэлт, маягтыг шинэчлэн баталсан. Энэхүү тушаалын нэгдүгээр хавсралтаар “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний өвчин, гэмтлийн жагсаалт”-ыг, хоёрдугаар хавсралтаар “Байнгын асаргаа шаардлагатай 0-16 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур үзүүлэлт”-ийг, гуравдугаар хавсралтаар “Байнгын “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй насанд хурсэн иргэний үнэлэх шалгуур, үзүүлэлт”-ийг дөрөвдүгээр хавсралтаар “Байнгын асаргаа шаардлагатай ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэний тодорхойлолт”-ыг, тавдугаар хавсралтаар “Байнгын асаргаа шаардлагатай, хүнд хэлбэрийн 0-16 насны хүүхдийн хөгжлийн</p>	2025.03.01 - 2025.06.30	60%
----	---	---------------------------	----	-----	--	-------------------------------	------------

					бэрхшээлийг тодорхойлох өвчин, гэмтлийн жагсаалт, шалгуур"-ыг тус тус шинэчлэн баталсан. Дээрх жагсаалтыг шинэчлэн батлуулах хэрэгцээ шаардлага үүссэн эсэх талаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт албан бичиг хүргүүлж, жагсаалтыг шинэчлэн боловсруулж, холбогдох байгууллага, иргэдээс санал авч нэгтгэн 2025 онд шинэчлэн батлуулахаар төлөвлөж байна.		
2.	Арга хэмжээ 2.2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусlamж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулахад хамtran оролцох	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 26.1.1-26.1.6-д заасан тусlamж, хөнгөлөлтийг олгох зорилгоор Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусlamж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ыг баталсан. Энэхүү журмыг шинэчлэн боловсруулж батлуулах хэрэгцээ шаардлага үүссэн бөгөөд журмын төслийг шинэчлэн боловсруулах, холбогдох байгууллага, иргэдээс санал авч нэгтгэн боловсруулахад хамtran оролцож байна.	2025.03.01 - 2025.06.30 <i>60%</i>	
3.	Арга хэмжээ 2.3. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлж байгаа тусlamж, хөнгөлөлтийн үйлчилгээг сайжруулах сургалт зохион байгуулах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар болон Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, олон нийтэд танилцуулж, хуулийн төсөлд өгсөн саналыг хамгийн боломжит хувилбараар хуулийн төсөлд тусган, саналын товьёгийг яамны цахим хуудсанд байршуулсан. Нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулахад халамжийн үйлчилгээ үзүүлдэг ажилтан, албан хаагчдыг чадавхжуулах сургалтыг үе	2025.03.01 - 2025.06.30 <i>70%</i>	

					шаттай зохион байгуулахаар төлөвлөж, 5 сэдвийн хүрээнд бэлтгэсэн цахим хичээлийг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүлээлгэн өгөхөөр бэлтгэж байна.	
--	--	--	--	--	---	--

**Зорилт 3. “Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах”
зорилтын хүрээнд**

1.	Арга хэмжээ 3.1. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх Ажлын хэсэг байгуулах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.2-т “нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн” гэж Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны түвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхөөс сонгогдсон өрхийн гишүүнийг хэлнэ гэж заасан.</p> <p>Үүний дагуу Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Аргачлал шинэчлэн батлах тухай” А/16, А/04 дүгээр хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал”-ыг, турavдугаар хавсралтаар “Захиргааны өгөгдөл үндэслэн орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох аргачлал”-ыг тус тус баталсан.</p> <p>Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал нь төрийн мэдээллийн бусад сангаас орлогыг орлуулан тооцох боломжтой</p>	2025.03.01 - 2025.06.30	100%
----	--	---------------------------	----	-----	---	-------------------------------	-------------

				<p>мэдээллийг авч, өрхийн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж, Монгол Улсын бүх өрхийн амьжиргааны түвшинг үнэлж, ядуурлын шугамаас доогуур буюу босго шугамаас доогуур өрхөөс амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг авч, нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг нарийвчлан тодорхойлох аргачлал юм.</p> <p>Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээг өрхийн мэдээллийн нэгдсэн санд үндэслэн үзүүлдэг учраас өрхийн мэдээллийн санг шинэчлэх хэрэгцээ шаардлага үүссэн. Иймд Өрхийн мэдээллийн нэгдсэн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ашиглалт, үйлчилгээг боловсронгуй болгох ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах зорилгоор Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/120 дугаар тушаалаар Ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж ажлын хэсгийн ахлагч Н.Мөнхсанчир холбогдох төрийн байгууллагаас мэдээлэл бүрдүүлэх ажлыг шуурхай хийх талаар ажлын хэсгийн гишүүдэд үүрэг өгсэн. Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт албан бичиг хүргүүлэн ажиллалаа.</p>	
--	--	--	--	--	--

2.	<p>Арга хэмжээ 3.2.</p> <p>Өрхийн мэдээллийн нэгдсэн санг орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлалын дагуу шинэчлэх</p>	<p>Гүйцэтгэлийн хувь 100%</p>	<p>0%</p>	<p>50%</p>	<p>Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн “Аргачлал шинэчлэн батлах тухай” А/16, А/04 дүгээр хамтарсан тушаалтын хоёрдугаар хавсралтаар “Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал”-ын дагуу өрхийн мэдээллийн санг шинэчлэн бүрдүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>Монгол Улсын 3.5 сая иргэн, 988.0 мянган өрхийн төрийн мэдээллийн бусад сангаас орлогыг орлуулан тооцох боломжтой 50 төрлийн хувьсах үзүүлэлтээр мэдээллийг бүрдүүлэх ажил хийгдэж байна.</p> <p>Төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцох үйл ажиллагааны хүрээнд Үндэсний статистикийн хороо, Татварын ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий, Авто тээврийн үндэсний төв, Төрийн албаны зөвлөлөөс орлогыг орлуулан тооцох боломжтой 47 төрлийн үзүүлэлтээр мэдээллүүдийг нэгтгэн авч дууссан. Нийгмийн даатгалын ерөнхий газартай мэдээлэл солилцох ажил үргэлжлэн хийгдэж байна.</p> <p>Мэдээллийн санг бүрдүүлж дууссанаар амьжиргааны түвшинг үнэлж оноо бодуулах бөгөөд ядуурлын шугамаас доогуур буюу босго шугамаас доогуур өрхөөс амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг авч, нийгмийн халамжийн дэмжлэг,</p>	<p>2025.03.01 - 2025.06.30</p>	<p>95%</p>

						туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийг тодорхойлох юм. Ингэснээр нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд үзүүлэх хүнс тэжээлийн дэмжлэг олгох үйлчилгээ, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төрөөс хариуцан төлөх, төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээг үзүүлэх, эрчим хүчний үнийн тарифын хөнгөлөлт үзүүлэх зэрэг үйлчилгээ зорилтот иргэндээ хүрэх юм.		
3.	Арга хэмжээ 3.3. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг тодорхойлох босго оноо тогтоох сайдын тушаалыг шинэчлэн батлуулах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.1.11-д "босго шугам" гэж нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн өрхийг амьжирааны түвшингээр эрэмбэлж оноо өгөх байдлаар тогтоосон хязгаарыг хэлнэ гэж заасан. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/97 дугаар тушаалаар батлагдсан "Босго оноо шинэчлэн тогтоох тухай" тушаалыг өөрчлөн боловсруулж босго оноог Үндэсний статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны "Аргачлал шинэчлэн батлах тухай" А/04, А/16 дугаар хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжирааны түвшин тодорхойлох хосолмол аргачлал"-ын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдсэн нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэнийг тодорхойлоо Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын	2025.03.01 - 2025.06.30	100%	

					2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн A/135 дугаар тушаалаар батлууллаа.		
Зорилт 4. “Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх” зорилтын хүрээнд							
1.	Арга хэмжээ 4.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусlamжийн чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах;	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Хууль тогтоомж, бодлогын баримт бичигт Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусlamжийн чиглэлээр хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээний биелэлтийг гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажиллалаа.	2025.03.01 - 2025.06.30	98%
2.	Арга хэмжээ 4.2. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх, хариу хүргүүлэх	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ирүүлсэн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүнд нийгмийн халамжийн сангаас үзүүлэх хөнгөлөлт, тусlamжийн талаар ирүүлсэн өргөдөл гомдол, санал хүсэлтийг хүлээн авч, холбогдох албан тушаалтанд танилцуулж, судлан шийдвэрлэж, хариу ёгч ажиллалаа.	2025.03.01 - 2025.06.30	99%
3.	Арга хэмжээ 4.3. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зохион бүрдүүлж буй баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг хэрэгжүүлж ажилласан	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Эрхлэх асуудал, чиг үүргийн хүрээнд албан бичиг болон тушаалын төсөл төлөвлөн боловсруулж, холбогдох албан тушаалтан, нэгжийн даргаар хянуулан албажуулж байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан. ГБХНХЯ-ны албан хаагчдын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, хагас, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайлангаар 47 боть хадгаламжийн нэгж үүсгэн, архивд хүлээлгэж өгсөн.	2025.03.01 - 2025.06.30	100%

4.	Арга хэмжээ 4.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	<p>2024 оны өөрийн болон гэр булийн гишүүдийн хөрөнгө, орлого, зээлийн эх үүсвэрийг бодитой, үнэн зөв хуульд заасан хугацаанд meduuuleg.mn цахим системд мэдүүлэн баталгааны хуудсыг байгууллагын эрх бүхий албан тушаалтанд гарган өгсөн. Албан тушаал шилжин томилогдсонтой холбогдуулан урьдчилсан мэдүүлэг хянуулан, хөрөнгө орлогын мэдүүлгээ тайлагнан ажиллалаа.</p> <p>2025 оны эхний хагас жилийн байдлаар Авлигын эсрэг хууль, Нийтийн албананд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан хязгаарлалтыг зөрчихөөр бэлэг, үйлчилгээ аваагүй бөгөөд хөрөнгө, орлогод хуулийн хязгаарлалт давсан өөрчлөлт ороогүй байна.</p>	2025.03.01 - 2025.06.30	166/
----	--	---------------------------	----	-----	---	-------------------------------	------

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)		5		
1	2	3	4					6	7
1.	Арга хэмжээ 1. Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар холбогдох дүрэм журмыг судлан, хариуцсан асуудлаар мэдлэг мэдээллийг эзэмшин нийгмийн халамжийн чиглэлээр мэргэшсэн төрийн албан хаагч болох талаар зорин ажиллаж байна.	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%				2025.03.01 - 2025.06.30	95/

	бүрэн уншиж судлан, хариуцсан асуудлаар мэргэшиг						
2.	Арга хэмжээ 2. Нийгмийн хalamжийн талаарх олон улсын туршлага, тайлан, мэдээ, дүн шинжилгээ, судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Нийгмийн хalamж, ядуурал, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх олон улсын туршлага, тайлан, мэдээ, дүн шинжилгээ, судалгаа, статистик, тоон мэдээллийг цаг алдалгүй хурдан шуурхай судлан албан ажлын чиг үүрэгт ашиглахад анхаарч ажиллаж байна.	2025.03.01 - 2025.06.30	00%
3.	Арга хэмжээ 3. Нийгмийн хalamжийн чиглэлээр сургалтад хамрагдах, бусад улсын туршлага судлах	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	2025 оны 09 дүгээр сард Ахмад настны тэтгэврийн чиглэлээр Бүгд Найрамдах Солонгос улсад богино хугацааны сургалтад хамрагдахаар хүсэлтээ хүргүүлсэн.	2025.03.01 - 2025.06.30	90%
4.	Арга хэмжээ 4. Албан хэргийг үндэсний бичгээр боловсруулан хөтлөн явуулах ур чадварыг эзэмших	Гүйцэтгэлийн хувь 100%	0%	50%	Монгол хэлний тухай хуульд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс Төрийн албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөн явуулахаар заасны дагуу тус яамнаас зохион байгуулсан Үндэсний бичгийн 16 цагийн сургалтад хамрагдаж албан хэргээ үндэсний бичгээр хөтлөх мэдлэг чадвараа дээшлүүлсэн.	2025.03.01 - 2025.06.30	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хөдөлмөрийн бодлогын газрын
Нийгмийн хalamжийн хэлтсийн
шинжээч
(Албан тушаал)

..... /О.Цэрэнлхам/
 (Нэр, гарын үсэг)

2025 - 06 - 04
..... (Огноо)

**АХМАД НАСТАН, ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ
ХӨНГӨЛӨЛТ, ТУСЛАМЖ, ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТ, ЗОХИЦУУЛАЛТ ХАРИУЦСАН ШИНЖЭЭЧ
ОЮУНБАТЫН ЦЭРЭНЛХАМЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ
ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хөдөлмөрийн бодлогын газрын Нийгмийн халамжийн хэлтэс

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	

**Зорилт 1. “Ахмад настны хөнгөлөлт, тусlamжийн бодлогын хэрэгжилтийг хангах”
зорилтын хүрээнд**

1.	Арга хэмжээ 1.1. “Ахмад настанд цогц тусlamж, үйлчилгээ үзүүлэхэд мэргэжлийн удирдлагаар хангах журам”-ын хэрэгжилтийг хангах	58,5	8	66,5	66,5
2.	Арга хэмжээ 1.2. Ахмад настанд цогц тусlamж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг ЭМЯ, ГҮТ-тэй хамтран боловсруулах	5,6	7	63	63
3.	Арга хэмжээ 1.3. Ахмад настанд цогц тусlamж үйлчилгээ үзүүлэх ажилтнуудыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	46	3	49	49

**Зорилт 2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусlamжийн бодлогын хэрэгжилтийг хангах”
зорилтын хүрээнд**

1.	Арга хэмжээ 2.1. Эрүүл мэндийн сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Жагсаалт, шалгuur үзүүлэлт, маягт шинэчлэн батлах тухай” 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/807, А/216 хамтарсан тушаалыг шинэчлэн боловсруулах	32	5	42	42
2.	Арга хэмжээ 2.2. “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тусlamж, хөнгөлөлт үзүүлэх журам”-ын төслийг шинэчлэн боловсруулахад хамтран оролцох	37	5	42	42

3.	Арга хэмжээ 3.3. Нийгмийн халамжийн сангаас хөгжлийн бэрхшээлтэй хүнд үзүүлж байгаа тусlamж, хөнгөлөлтийн үйлчилгээг сайжруулах сургалт зохион байгуулах	46	3	49	49
Зорилт 3. "Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах" зорилтын хүрээнд					
1.	Арга хэмжээ 3.1. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх Ажлын хэсэг байгуулах	60	10	70	70
2.	Арга хэмжээ 3.2. Өрхийн мэдээллийн нэгдсэн санг орлогыг орлуулан тооцох аргаар өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох хосолмол аргачлалын дагуу шинэчлэх	59,5	7	66,5	66,5
3.	Арга хэмжээ 3.3. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрх, иргэнийг тодорхойлох босго оноо тогтоох сайдын тушаалыг шинэчлэн баттуулах	60	10	70	70
Зорилт 4. "Төрийн албан хаагчийн нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх" зорилтын хүрээнд					
1.	Арга хэмжээ 4.1. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний хөнгөлөлт, тусламжийн чиглэлээр хууль тогтоомж, бодлогын баримт бичигт туссан зорилт, арга хэмжээний биелэлтийг гаргах, тайлагнах;	59,6	9	68,6	68,6
2.	Арга хэмжээ 4.2. Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлт, албан бичгийг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх, хариу хүргүүлэх	60,3	9	69,3	69,3
3.	Арга хэмжээ 4.3. Албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэх явцад зохион бүрдүүлж буй баримт бичгийг стандартын дагуу хөтлөн явуулах, архив, албан хэрэг хөтлөлтийн хуулийг хэрэгжүүлж ажиллах	60	10	70	70
4.	Арга хэмжээ 4.4. Авлигын эсрэг хууль, Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	60	10	70	70
Дундаж оноо:				67,3	67,2

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
2	3	4		
1.	Арга хэмжээ 1. Нийгмийн халамжийн тухай, Ахмад настны тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль болон ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүний талаар холбогдох дүрэм журмыг бүрэн уншиж судлан, хариуцсан асуудлаар мэргэших	95	14,25	14,25
2.	Арга хэмжээ 2. Нийгмийн халамжийн талаарх олон улсын туршлага, тайлан, мэдээ, дүн шинжилгээ, судалгаа, статистик, тоон мэдээллийг судлах	90%	13,5	13,5
3.	Арга хэмжээ 3. Нийгмийн халамжийн чиглэлээр сургалтад хамрагдах, бусад улсын туршлага судлах	90%	13,5	13,5
4.	Арга хэмжээ 4. Албан хэргийг үндэсний бичгээр боловсруулан хөтлөн явуулах ур чадварыг эзэмших	100	15	15
Дундаж оноо			14,06	14,0

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
2	3		
1.	Хандлага, ёс зүй	7	7
2.	Дүн шинжилгээ хийх	7	7
3.	Асуудал шийдвэрлэх	7	7
4.	Хариуцлагатай байдал	7	7
5.	Ажлын цаг ашиглалт	7	7
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.	7	7
7.	Мэргэжлийн ур чадвар 2.	7	7
8.	Мэргэжлийн ур чадвар 3.	7	7
Дундаж оноо		7	7

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
		1
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо		8

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлттүүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 61,22 61,2

2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 14
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 7
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо =		
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо	90,282 90,2	

Үнэлгээ өгсөн:

Нийгмийн халамжийн
хэлтсийн дарга
(албан тушаал)

Нэгжийн дарга

(гарын үсэг)

/О.Отгонбилэг/
(албан хаагчийн нэр)

2025.06.13..... (огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшилцөн:**

НХХ-ийн шинжээч
(албан тушаал)

Төрийн жинхэнэ албан хаагч:

(гарын үсэг)

/О.Цэрэнлхам/
(албан хаагчийн нэр)

2025.06.13..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Ж.УГ-РН ӨВНӨГ
(албан тушаал)

(гарын үсэг)

/В.Чувшин таргат
(албан хаагчийн нэр)

2025.06.20.... (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

(албан тушаал)

(гарын үсэг)

/Д.Баянтаргал.../
(албан хаагчийн нэр)

2025.06.20.. (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төрийн нарийн бичгийн дарга
(албан тушаал)

Төсвийн шууд захирагч

(гарын үсэг)

/Л.Мөнхзул/
(албан хаагчийн нэр)

